

## Монгол улсын мөнгөний бодлогын хэрэгжилт

Б.Баярдаваа \*  
Б.Лхагважав \*\*

*Abstract: The Mongolian economy has been producing a strong double digit growth. This presentation reviews some key macroeconomic indicators, such as GDP growth, inflation etc., and briefly outlines the mandate of the Bank of Mongolia and monetary policy guidelines for 2015.*

\* \* \*



Улс төр, нийгэм, эдийн засагт шинэчлэл хийгдэж 1990 онд “Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм”, 1991 онд “Банкны тухай хууль” батлагдсанаар Монгол Улсад 2 шатлалт банкны тогтолцооны хөрс суурь тавигджээ.

Банкны 2 шатлалтай тогтолцоонд шилжсэнээс хойш өдгөөг хүртэл арилжааны 31 банк байгуулагдаж, үйл ажиллагаа явуулснаас 17 банк нь өөрийн үйл ажиллагааны алдаа, эндэгдлээс шалтгаалан санхүү, төлбөрийн чадваргүй болон дампуурч, дүрмийн санг тогтоосон хэмжээнд хүргээгүй, бусад банктай нэгдэх, татан буугдах зэргээр үйл ажиллагаагаа зогсоож Монгол банкнаас олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Шилжилтийн хүнд хэцүү үед Монгол банкныг толгойлох, 2 шатлалтай банкны тогтолцоог бэхжүүлэх хүндхэн үүрэг харууллага Н.Жаргалсайхан, Д.Моломжамц, Ж.Үнэнбат, О.Чулуунбат, А.Батсүх, Л.Пүрэвдорж нарт оногдож байжээ. Тэд банкны системийн тогтвортой байдлыг хангах, мөнгөний нийлүүлэлтийг зохистой түвшинд

\* Монгол Банкны Мөнгөний бодлого, судалгааны газрын ахлах эдийн засагч

\*\* Монгол Банкны Мөнгөний бодлого, судалгааны газрын ахлах эдийн засагч

## ОЛОН УЛС СУДЛАЛ

барих, төгрөгийн ханшийг хамгаалах, инфляцийн түвшинг тууштай бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих тал дээр анхаарал тавин, хүчин чармайлт гарган ажиллаж байв.

Монгол банк өдгөө 2 аймгийн хэлтэс, 15 аймгийн салбар, Английн Лондон хотод төлөөлөгчийн газартай, 300 гаруй ажиллагсадтайгаар төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, арилжааны банкуудын үйл ажиллагааг хянан чиглүүлж байна. Олон улсын түвшинд Монгол банкны хамтын ажиллагаа өргөжиж дэлхийн олон орны Төв банкуудтай ажил хэргийн холбоотой болоод байна.

2014 оны байдлаар нийт 13 арилжааны банк үйл ажиллагаагаа явуулж байгаагаас төрийн өмчийн /Төрийн банк/ нэг банк байна. Эдгээр банкны 1386 салбар, нэгжээр дамжуулан Монгол Улсын бүх аймаг, хот, сум, суурин газруудад үйлчилж байгаа бөгөөд тэдгээрт 13.564 ажиллагсад ажиллаж манай улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд банкны үйлчилгээг хүргэж байна.

Төв банк инфляцийг нам тогтвортой түвшинд байлгах замаар иргэдийн бодит орлогыг хамгаалах, хэрэглээ болон хөрөнгө оруулалтыг дэмжих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн тогтвортой өсөлтийн орчинг бүрдүүлэхийг зорьж байна. Инфляцийг тогтворжуулах нь эдийн засаг дахь тодорхой бус байдлыг бууруулах, нөөцийн үр ашигтай хуваарилалт явагдах ач холбогдолтой юм.

Монгол банк ханшийн уян хатан тогтолцоог хэрэгжүүлсээр ирлээ. Төгрөгийн ханш эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэйгээр хэлбэлзэж байна. Монгол банк ханшийн өөрчлөлтийн хандлагыг бүрэн өөрчлөлгүйгээр зөвхөн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор валютын захад нээлттэй оролцож байна. Ингэснээр хувийн секторт дасан зохицох, зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангах, ханшийн савалгаанаас үүдэн санхүүгийн салбарт үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах боломжийг олгож, валютын ханшийн уян хатан бодлого хэрэгжүүлэх эрмэлзлийн илэрхийлэл болдог билээ.

Эдийн засгийн өсөлт 2014 онд 6.4%, 2015 онд 6.3% гарах урьдчилсан тооцоотой байна. 1) Гадаад эрэлт сэргэх төлөвгүй, 2) өрхийн өр, орлогын харьцаа өндөр байгаа нь хувийн хэрэглээг хязгаарласан, 3) төсвийн орлогын тасалдлаас үүдэн төсвийн урсгал зардал, хөрөнгө оруулалт буурах шаардлагатай байгаа, 4) гадаад валютын нөөцийн хэмжээ багассан нь дотоод эрэлтийг дэмжих бодлогын орон зайг олгохгүй байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2014 оны эхний 8 сарын байдлаар 7,175.6 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар буюу 215.5 сая ам.доллараар өссөн. Гадаад худалдааны нөхцөлийн индекс /2012 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.63-д хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.9 хувиар өссөн ба үүнд импортын үнийн индекс 18.6 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Импортын үнийн индекс буурахад удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, барилгын материал болон нефтийн бүтээгдэхүүний хилийн үнэ буурсан нь нөлөөлжээ.

Төлбөрийн тэнцлийн төсөөллөөр 2014 онд урсгал данс 1.8 тэрбум ам.долларын алдагдалтай байх бол хөрөнгө санхүүгийн дансны ашиг 730 сая ам.доллар байхаар таамаглалаа. Иймд нийт төлбөрийн тэнцлийн алдагдал 1.4 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Төлбөрийн тэнцлийн энэхүү алдагдлыг ГВЦАН-өөр санхүүжилснээр 2014 оны эцэст уг нөөц -214 сая ам.доллар хүрч буурахаар байна.

Төлбөрийн тэнцлийн алдагдлаас шалтгаалан 2014 оны 7 сарын байдлаар гадаад валютын албан нөөцийн хэмжээ 1349.2 сая ам.долларт болж, оны эхнээс 40 хувиар буурсан байна. Энэ нь валютын төлбөртэй импортын 12.1 долоо хоногийн хэрэгцээг хангахаар байгаа нь олон улсын жишиг түвшин болох 12 долоо хоногийн үзүүлэлтийг хангаж байгаа үзүүлэлт юм.

Монгол банк ханшийн уян хатан тогтолцоог хэрэгжүүлсээр ирлээ. Төгрөгийн ханш эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэйгээр хэлбэлзэж байна. Худалдааны нөхцөл муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсны улмаас ам. доллартай харьцах төгрөгийн ханш сүүлийн 12 сарын байдлаар 20 хувиар суларсан байна. Нэрлэсэн ханш

## ОЛОН УЛС СУДЛАЛ

ингэж суларсан нь гадаад худалдааны нөхцөл муудсан, гадаадын хөрөнгө оруулалт буурсан өнөөгийн орчинтэй нийцтэй байна. Нэрлэсэн ханш суларч бодит үйлчилж буй ханш урт хугацааны тэнцвэртэй ойртож, төгрөг хэт үнэлэгдэх эрсдлээс сэргийлсэн юм. Ханшийн энэхүү өөрчлөлт нь богино хугацаанд тодорхой зардлыг дагуулах ч урт хугацаанд өөрийн ач тусаа өгнө гэдэгт миний бие итгэлтэй байна.

Монгол шиг гадаад худалдааны эргэлт нь ДНБ-ээс давсан эдийн засгийн хувьд валютын ханшийн хэтэрхий огцом өөрчлөлт нь эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй байдаг билээ. Тийм учраас Монголбанк ханшийн өөрчлөлтийн хандлагыг бүрэн өөрчлөлгүйгээр зөвхөн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор валютын захад нээлттэй оролцож байна. Ингэснээр хувийн секторт дасан зохицох, зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангах, ханшийн савалгаанаас үүдэн санхүүгийн салбарт үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах боломжийг олгож, валютын ханшийн уян хатан бодлого хэрэгжүүлэх эрмэлзлийн илэрхийлэл болдог билээ. Одоогийн ханшийн түвшин нь эдийн засгийн суурь үзүүлэлтүүдтэй нийцтэй бөгөөд манай эдийн засгийн өрсөлдөх чадвар болон экспортыг нэмэгдүүлэх, дотоодын хөрөнгө оруулалтыг өсгөх зорилготой нийцтэй юм.

Гадаадын хөрөнгө оруулалт буурч, гадаад валютын дотогшлох урсгал саарснаар эдийн засагт хөрөнгийн дутагдал бий болж зээл олголт тасалдах, улмаар эдийн засгийн идэвхжил буурах эрсдэлтэй байсан тул Монголбанк үнэ тогтворжуулах хөтөлбөр, ипотекийн зээл зэрэг хөтөлбөрүүдийг санхүүжүүлж мөнгөний өсөлтийг тогтвортой хадгалж чадсан. Тодруулбал, 2012 оны 4 дүгээр улиралд 4.4 их наядын үлдэгдэлтэй байсан гадаад цэвэр актив (ГЦА) 2013 оны 4 дүгээр улиралд 934 тэрбум төгрөг болж буурсан бол мөн хугацаанд дотоод цэвэр актив (ДЦА) 3.2 их наядаас 8.5 их наяд төгрөгт хүрч өссөн байна. ДЦА, ГЦА-ын нийлбэрээр 2013 оны 2 дугаар улирлаас эхлэн М2 мөнгөний өсөлт тогтмол нэмэгдэж 2014 оны 4 дүгээр сард жилийн 42 хувьд хүрч, зээлийн өсөлт 2013 оны 3 дугаар улирлаас 2014 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд тогтмол 50%-иас өндөр байсан байна.

Монгол улсад өндөр инфляцийн нэлээдгүй хэсгийг нийлүүлэлтийн буюу зардлын хүчин зүйлс, тэр дундаа хүнс, шатахууны тасалдал, дэд бүтцийн түгжрэлүүд тодорхойлсоор ирсэн билээ. Нийлүүлэлтийн шок нь заримдаа цөөн тооны нийлүүлэгчид бараа, үйлчилгээгээ зах зээлд өндөр үнээр нийлүүлэх эрмэлзлээр ч илэрч байсан юм.

Нийлүүлэлтийн шокийг арилгах хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү дунд хугацааны хөтөлбөр нь үндсэн бараа бүтээгдэхүүн болох бензин шатахуун, мах, буудайны жижиглэн үнийг тогтворжуулах, зах зээлийн зарчимд суурилсан агуулахын санхүүжилтийн механизмыг шинээр бий болгоход чиглэгдэж байгаа юм. Бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг цоо шинээр нэвтрүүлснээр бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоог бүрдүүлэх боломжтой болно.

ХҮИ улсын хэмжээгээр 2014 оны 8 дугаар сарын эцэст өмнөх сараас 0.4 хувь, оны эхнээс 7.7 хувь, өмнөх оны мөн үеэс 13.7 хувь, Улаанбаатар хотын ХҮИ өмнөх сараас 0.7 хувь, оны эхнээс 7.4 хувь, өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар тус тус өслөө.

Инфляци 2014 оны эцэст 12.1% 2015 оны эцэст 9.5% гарах төлөвтэй байна. Хэдийгээр он гарсаар үйлдвэрлэлийн зөрүү сөрөг болж үйлдвэрлэлийн өсөлт саарч инфляцийг бууруулах чиглэлд байгаа боловч өнгөрсөн оны хэрэглээ хөрөнгө оруулалтыг тэлсэн шийдвэрүүд, түүний нөлөө нь энэ оны инфляцид дарамт учруулсаар байна. 2015 оны хувьд эрэлтийн зүгээс инфляцид үзүүлэх дарамт бага байхаар байна. Гэвч нөгөө талаас төгрөгийн ханшийн сулралт бараа бүтээгдэхүүний зардлыг өсгөсөнөөр инфляцид ирэх дарамт нь багасахааргүй байна.

Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихийн тулд Монгол банк бодлогын хүүгээ нийт 2.75 нэгж хувиар бууруулж, 850 тэрбум төгрөг буюу М2 мөнгөний 15 хувьтай тэнцэх хэмжээний хадгаламжийг банкуудад байршуулснаар 2012 оны сүүлээс үүсч болзошгүй байсан зээлийн тасалдлыг сэргийлж чадав.

Түүнчлэн банкны системийн хяналт шалгалтад анхаарч, зохистой харьцааны дүрэм журмыг сайжруулан санхүүгийн секторт итгэх

итгэлийг хамгаалан ажиллав. Энэ оны 5 сараас эхлэн манай бүх банк зохистой харьцааны болон өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүдээ бүрэн ханган ажиллаж байна. Нэг банкны хувьд сүүлийн 2 жилийн турш Монгол банктай хамтран тусгай хөтөлбөрөөр ажилласан боловч хүлээгдсэн үр дүн гаралгүй хаалгаа барихад хүрсэн. Монгол улс даяар 500 гаруй салбар, нэгжтэй банкыг татан буулгаж, өөр нэг банк түүний цэвэрлэсэн хэсгийг хүлээн авах ажлыг төлбөр тооцоо саатуулалгүйгээр, активын алдагдалгүй нэг өдрийн дотор гүйцэтгэлээ. Харин 2 сарын дараа нийлсэн 2 банкны тайлан тэнцэл өсөөд эхэлсэн байна.

Мөнгөний бодлогыг эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангаж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, эдийн засаг дунд, урт хугацаанд тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчинг бүрдүүлэхэд чиглүүлнэ.

Макро эдийн засгийн тогтвортой байдал нь төлбөрийн тэнцлийн зохистой байдал, үнийн тогтвортой байдал, бодит эдийн засаг тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчин бүрдсэнээр хангагдана. Эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэртэй байдал нь эдийн засгийн шингээх чадвар, хуримтлал, хөрөнгө оруулалтын оновчтой бодлого болон төсөв, мөнгөний зохистой бодлогын хослолын үр дүн байдаг. Иймээс Монголбанк ирэх онуудын мөнгөний бодлогыг эдийн засгийн тэнцвэртэй орчинг бүрдүүлж, эдийн засгийн дархлааг сайжруулахад чиглүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Цаашид Засгийн газрын зүгээс төсвийн тогтвортой байдлыг ханган, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулан, гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, Монгол банкнаас банкуудын эрсдэл даах чадварыг бэхжүүлж, төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцлийн хямралаас гарах нь ойрын хугацааны бодлогын эн тэргүүний зорилт болоод байна. Дунд хугацаанд инфляцийг эрчимжүүлэхгүй байж иргэдийн бодит орлогыг хамгаалах, эдийн засгийн өсөлтийг сэргээж, тогтворжуулах, санхүүгийн салбарын дархлааг сайжруулахад чиглэсэн мөчлөг сөрсөн мөнгө, төсвийн болон макро зохистой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв байдалтай уялдуулан мөнгөний бодлогын үндсэн чиглэл нь эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг ханган инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах замаар эдийн засгийн тогтвортой байдлыг ханган, улмаар дунд, урт хугацааны эдийн засгийн тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөлтийн суурь нөхцлийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр Монгол банк төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлд дараах үндсэн заалтыг санал болгоод байна. Үүнд:

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2015 оны эцэст 7 хувьд, 2016-2017 онд энэ түвшинд тогтворжуулсны үндсэн дээр иргэдийн бодит орлогыг үнэгүйдлээс хамгаалж, эдийн засаг тогтвортой өсөх суурь нөхцлийг бүрдүүлнэ.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь гадаад тэнцвэрийг хангахуйц уян хатан тогтож, эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дэмжих зарчмыг баримтална.

Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, мөнгөний бодлогын үндсэн зорилт болон хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах ажлыг үргэлжлүүлж Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хадгална.

2011 оны 5 дугаар сарын 6-нд Монгол банк, Хятадын Ардын Банк “Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээнд гарын үсэг зурав. Энэхүү гэрээ нь хоёр улсын төв банк хоорондын хамтын ажиллагаанд чухал алхам болоод зогсохгүй хоёр улсын банк, санхүү, эдийн засгийн харилцааны цаашдын хөгжлийг түргэтгэх, дэмжихэд гол хөшүүрэг болсон юм. БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдааны гол түнш орон бөгөөд БНХАУ-ын юань Монгол Улсын валютын зах зээлд идэвхитэй арилжаалагддаг хоёрдахь гадаад валют юм. Иймд Монгол банк, Хятадын ардын банк хооронд дээрх своп хэлцлийн гэрээ байгуулагдсанаар Монгол Улсын гадаад худалдааны гол түнш орон болох БНХАУ-ын юанийг Монгол банк түргэн шуурхай бүрдүүлж, арилжааны банкуудын юаниар төлбөр түргэн гүйцэтгэх чадварт хүндрэл гарч валютын дотоодын захад тогтворгүй байдал

үүссэн тохиолдолд захад юанийг шуурхай нийлүүлэх замаар үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх боломжтой болсон юм.

2014 оны 8 дугаар сарын 21-ний өдөр Монгол банкны Ерөнхийлөгч Н.Золжаргал, Хятадын Ардын банкны Ерөнхийлөгч Жоу Шиачуан нар Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн хэмжээг 10 тэрбум юаниас 15 тэрбум юань болгож нэмэгдүүлэх шинэ гэрээнд гарын үсэг зурлаа. Свop хэлцлийн гэрээг шинэчлэн байгуулснаар 2011 оны 5 дугаар сарын 06-ны өдөр байгуулж, 2014 оны 5 дугаар сарын 14-ний өдөр сунгасан 10 тэрбум юанийн дүнтэй “Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээ” хүчингүй болсон бөгөөд шинэ гэрээ гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэллээ.

2011 онд своп хэлцлийн гэрээг анх байгуулж байсан цагаас хойш Монгол банк, Хятадын Ардын банкны харилцаа бүх талаар өргөн хүрээтэй хөгжиж байгаа бөгөөд 2 талын ихээхэн хүчин чармайлтын үр дүнд своп хэлцлийн хэмжээг ийнхүү нэмэгдүүлж, төв банкуудын хоорондох хамтын ажиллагааг хөгжлийн шинэ шатанд авчирлаа.

Свop хэлцлийн хэмжээг нэмэгдүүлэх нь гадаад валютын дотоодын захад тогтвортой байдлыг хангах үүднээс шаардлагатай тохиолдолд гадаад валютын зах дээр төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, мөн 2 орны худалдаа, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх зорилготой.

БНХАУ нь Монгол Улсын худалдааны гол түнш орон бөгөөд БНХАУ-ын юань нь Монгол Улс болон БНХАУ хоорондын хил худалдааны төлбөр тооцоонд идэвхтэй арилжаалагддаг 2 дахь валют юм.

Дашрамд дурдахад, Дэлхийн банк хоорондын санхүүгийн цахилгаан холбооны (SWIFT) нийгэмлэгийн судалгаагаар БНХАУ-ын юань нь энэ оны 6 дугаар сарын байдлаар дэлхийн идэвхтэй арилжаалагддаг валютуудын 7 дугаарт эрэмбэлэгдсэн бөгөөд 2013 онд худалдааны санхүүжилтэд ашиглагддаг 2 дахь идэвхтэй валютаар шалгарсан байна.